

## **ХАВДРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ХУВЬ ХҮНИЙ ХАЛААСНААС ГАРАХ АЛБАН БА АЛБАН БУС ТӨЛБӨРИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**ҮНДЭСЛЭЛ:** Дэлхийн хорт хавдрын судалгааны сангийн 2020 оны статистик мэдээгээр Монгол улс 100 000 хүн амд ноогдох элэг болон ходоодны хорт хавдрын өвчлөл, нас баралтаараа Дэлхийд нэгдүгээрт бичигдсэн байна. Үндэсний статистикийг хорооны 2020 онд гаргасан “Хавдрын өвчлөл, нас баралт” сүүлийн 10 жилийн баримтын судалгаанд хорт хавдраар оношлогдсон хүмүүсийн 80% нь III, IV үе буюу хожуу шатандаа оношлогддог гэсэн дүгнэлт гаргажээ.

Дэлхийд Монгол улс хорт хавдрын нас баралтаараа дээгүүрт ордгийн гол шалтгаан нь эрт оношлогдож чадаагүй, оношилгоо эмчилгээний зардалд их хэмжээний мөнгө шаардагддаг зэрэг шалтгаанууд ордог байна. Иймээс иргэдэд учирдаг санхүүгийн дарамтыг багасгахаар “ЭМДҮЗ-н III тогтоол” 2021 онд батлагдан хэрэгжиж эхлэсэн байна. Уг тогтоол хэрэгжиж эхэлснээр хавдрын тусламж үйлчилгээний чиглэлээр иргэдээс гарах зардлыг судлах судалгаа хийгдээгүй байгаа тул бид ХСҮТ-н тусламж үйлчилгээний өнөөгийн байдалтай уялдуулан цогцоор нь судалсан.

**ЗОРИЛГО:** ХСҮТ-н тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, хүлээгдэл, хавдрын тусламж үйлчилгээний үед хувь хүнээс гарах албан ба албан бус зардлыг судлах

### **ЗОРИЛТ:**

1. Сүүлийн 5 жилийн хугацаанд ХСҮТ-д үйлчлүүлсэн иргэдийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийх
2. ХСҮТ-ийн тусламж үйлчилгээ, цаг товлох үйлчилгээний одоогийн байдал, хүлээгдэл, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох
3. Хавдрын тусламж үйлчилгээний үед хувь хүнээс гарах албан ба албан бус зардал, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг судлах

Судалгаанд хамруулсан тусламж үйлчилгээний төрлүүд:

Судалгаанд ХСҮТ-н Мэс заслын клиникийн-6, Хавдрын өвөрмөц эмчилгээний клиникийн-3, Амбулаторийн-13, Оношзүйн-5 буюу нийт 27 тусламж үйлчилгээг хамруулан судалсан. ХСҮТ-ийн 200 үйлчлүүлэгчээс Google form хэлбэрээр 7 бүлэг, 60 асуулт бүхий асуумж боловсруулж цуглуулсан.

Судалгааны үр дүн, тайлан боловсруулалт:

Судалгааны мэдээллийг Excel програм дээр дата болгон цэвэрлэж, STATA програм дээр үр дүнгийн статистик боловсруулалтыг хийсэн. Үр дүнгийн үзүүлэлтэд дескриптив шинжилгээ хийж, хүснэгт, зураг, схем хэлбэрээр харуулан 53 хуудас бүхий тайлан боловсруулсан.

### **Үр дүн:**

1. ХСҮТ-д жилд дунджаар 106,415 хүн үйлчлүүлдэг, амбулатори стационарын үйлчлүүлэгчдийн тоо сүүлийн 5 жилд эрчимтэй нэмэгдэж байгаа тул ачааллаас үүдэн хавдрын идэвхитэй хяналт сүүлийн 2 жил хийгдээгүй.
2. Үйлчлүүлэгчдийн 78,3% нь цаг товлох үйлчилгээг өөрийн биеэр авдаг ба 43% нь 14 хоног ба түүнээс дээш хугацаанд хүлээдэг.

3. Албан бус зардлын дийлэнхийг урсгал зардлууд эзэлдэг бол албан зардлын оношилгооны зардалд дунджаар үйлчлүүлэгчдийн 44,2% нь, эмчилгээний зардалд 9,5% нь хувиасаа 20 сая хүртэлх төгрөгний зардал гаргадаг байна.

#### Дүгнэлт:

ЭМС-ын А/611 дугаар тушаалын “Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд нь бүртгэгдсэн хүн амын төрөлт, нас баралт, эх, хүүхдийн эндэгдэл, амбулатори, стационарын тусламж, үйлчилгээний үзүүлэлтүүдийг улсын тайлан маягт ЭМТ - 501.1 - ын дагуу сар бүр цахим хэлбэрээр мэдээлнэ” гэсний дагуу ХСҮТ мэдээ, тайлангаа хүргүүлдэг ч ХСҮТ-ийн өдрийн эмчилгээ нь стационарын тусламж үйлчилгээнд ордоггүй мөн амбулаторийн үзлэгийн төрөлд хамаарахгүй байгаагаас ЭМТ-501.1 маягтын дагуу 6702 үйлчлүүлэгчийн статистик мэдээлэл мэдээлэгдэхгүй, цахим мэдээний санд орохгүй байна.

Улаанбаатар хотоос хэвтэн эмчлүүлэгчдийн дийлэнх нь хөнгөвчлөх болон хавдрын өвөрмөц эмчилгээний тусламж үйлчилгээ авдаг бол хөдөө орон нутгийн үйлчлүүлэгчид дийлэнхдээ мэс засал болон хавдрын өвөрмөц эмчилгээний тусламж авдаг байна.

ХСҮТ нь амбулаторийн үзлэгийн цаг товлох үйлчилгээг ДЗА-аар дамжуулан цаг товлох үйлчилгээг авах нь иргэдэд төөрөгдөл, хүндрэл учруулж байгаа тул эмнэлгийн тасаг нэгжийн бүртгэл мэдээллийг шинэчилж өгөхөөр ДЗА-д мэдэгдсэн. Мэдэгдлийн протокол болон хөтлөлт байхгүй нь ДЗА-ыг гомдол санал хүсэлтийн бүртгэл мэдээллийг хөтөлдөггүй гэж дүгнэж байна.

Албан зардлыг оношилгоо, эмчилгээний зардал гэж ангилан үзэхэд лабораторийн шинжилгээ, рентген оношилгоо болон маммографийн шинжилгээний зардлыг ЭМД-н сангаас бүрэн төлж байсан ба компьютер томографи, MRI, дурангийн оношилгоонд иргэд хувиасаа түлхүү зардал гаргаж байсан байна. Зардал гаргасан иргэдийн дийлэнх нь оношилгоог хувийн эмнэлгүүдэд хийлгэсэн байсан. Үүнд: Медпортал (*ХСҮТ-н зүүн жигүүрт байрлах эмнэлэг*), Бриллиант (*ХСҮТ-н ард байрлах*), Сонгдо, Гранмед, Мөнгөн гүүр, Гялс төв, Интермед зэрэг эмнэлгүүд багтаж байна.

Эмчилгээний хувьд 90,5% нь ЭМД-р хөнгөлүүлсэн буюу хувиасаа зардал гаргаагүй, 9,5% нь хавдрын мэс заслын эмчилгээ болон өвөрмөц эмчилгээнээс гадна хими эмчилгээний зарим эм, тариа, цагаан эс, уураг, дэмжих эмчилгээнд зарцуулагдсан байна.

Үйлчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийг харахад 61,7 хувь нь маш сайн, сайн гэсэн үнэлгээг өгч, 27 хувь нь дунд зэргийн сэтгэл ханамжтай байна гэж хариулсан байна.